

2018 ОНЫ 7 ДУГААР САРЫН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮЛЭЭГДЛИЙН МЭДЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/427 тушаалын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдэл бүртгэгдсэн 9 байгууллага /УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, ГССҮТ, СЭМҮТ, НЭМГ, УАУТ/ мэдээ ирүүлсэн.

Нэг. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн амбулаторийн үзлэгийн хүлээгдэл:

2018 оны 7 дугаар сард хүлээгдлийн мэдээ ирүүлсэн байгууллагуудаас УНТЭ амбулаторийн үзлэг 96, УГТЭ 154, УХТЭ 224 хүлээгдэл бүртгэгдсэн байна. Өмнөх сарын хүлээгдэлтэй харьцуулахад УНТЭ-ийн хүлээгдлийн тоо буурсан УХТЭ, УГТЭ 51 тохиолдлоор хүлээлгийн тоо өссөн байна.

УНТЭ-ийн амбулаторийн 12 кабинетэд нийт 96 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдэж өмнөх сарын хүлээгдлээс 191 үйлчлүүлэгчээр буурсан байна. Үүнд:

- Мэс засал 1
- Нүд 1
- Булчирхай 5
- Урологи 3
- Мэдрэл судлал 14
- Хоол боловсруулах эрхтэн судлал 5
- Үе судлал 66

Цус судлалын кабинетэд 1 үйлчлүүлэгч, тус бүр 1-7 хоногийн хугацаатай хүлээсэн байна. 4 кабинет хүлээгдэлгүй ажиллажээ.

УХТЭ-т нийт 11 кабинетэд 224 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн байгаа нь өнгөрсөн сарынхаас 75 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна. Үүнд:

- Бөөр судлал 33
- Зүрх судас 46
- Уушиг 20
- Мэс засал 3
- Мэдрэл судлал 44
- Хоол боловсруулах эрхтэн судлал 41
- Чих хамар хоолой 5
- Эмэгтэйчүүдийн кабинетэд 15 үйлчлүүлэгч тус тус 1-6 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 12 кабинетэд 182 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

УГТЭ-т 3 кабинетэд 154 үйлчлүүлэгч хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Зүрх судас 58, уушиг, мэдрэлийн эмчийн үзлэг тус бүр 48 үйлчлүүлэгчийн хүлээгдэл бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 58 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн, мэдрэлийн кабинетэд 48 үйлчлүүлэгч хүлээгдэлтэй үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 17 кабинетэд 363 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.


ХСҮТ-ийн амбулаторийн 8 кабинетэд нийт 110 үйлчлүүлэгч хүлээгдэлд бүртгэгдсэн нь өмнөх сарын хүлээгдлээс 20 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна. Үүнд:

- Элэг цөс нойр булчирхайн кабинет 29
- Цээжний хөндийн мэс засал 11
- Эмэгтэйчүүдийн мэс заслын 26
- Ерөнхий мэс заслын кабинет 13
- Толгой хүзүүний мэс засал 17
- Хөнгөвчлөх эмчилгээнд 2
- Гепатологийн кабинет 3
- Ангиографийн кабинетэд 4 үйлчлүүлэгч тус бүр 1-7 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ. Өдөртөө үйлчлүүлсэн 15 үйлчлүүлэгч бүртгэгдсэн байна.

/ ХСҮТ нь нийт 19 кабинеттэйгаар амбулаторийн үзлэг хийдэг. Үүнээс сэтгэл зүйч, хоол зүйч нь хэвтэн эмчлүүлэгч, тэдний ар гэрийнхэнд зөвлөгөө өгдөг ба хими-2 кабинет нь амбулаторит давтан үзлэг буюу хяналтын өвчтөнүүдийн үзлэг хийдэг. 7-р сард Ерөнхий хавдар судлал, Эмэгтэйчүүдийн мэс засал-I кабинетийн эмч нар амралттай байсан. Амбулаторит хүлээгдэж буй үйлчлүүлэгчдийн тоо нь ХСҮТ-н амбулаториор анх удаа тус төвд үзүүлэхээр ирсэн үйлчлүүлэгчдийн мэдээлэлд үндэслэн хүлээгдлийн мэдээг гаргав./

ЭХЭМҮТ нь 7 сард амбулаторийн хүлээгдэлгүй ажилласан.

УНТЭ, УХТЭ, УГТЭ-ийн 7-р сарын амбулаторийн хүлээгдлийг үйлчлүүлэгчдийн тоогоор харьцуулсан нь:



Хоёр. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн оношлогооны кабинетийн хүлээгдэл:

2018 оны 7 дугаар сард УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, СЭМҮТ-ийн оношлогооны тасгуудад хүлээгдэл бүртгэгдсэн байна.

УНТЭ-ийн рентген 318 үйлчлүүлэгч 1-7 хоног хүлээгдэж байгаа нь өмнөх сарын хүлээгдлээс 115 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна. Үүнд:

- Рентген зураг 133
- Зүрхний цахилгаан бичлэг 7
- Хэвлийн эхо 92
- Тархины цахилгаан бичлэг 5
- MRI шинжилгээ 34
- Захын судасны ЭХО 33

- Радиоиммунологи 44
- Бүдүүн гэдэсний дуран 3 үйлчлүүлэгч оношлуулахаар 3-14 хоног тус тус хүлээж үйлчлүүлсэн байна.


УХТЭ-т рентген зураг авахуулахаар 133 үйлчлүүлэгч 3-14 хүлээгдэж байгаа нь өмнөх сарын хүлээгдлээс 83 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна. Хэвлийн эхо 92 үйлчлүүлэгч хүлээгдэж байгаа нь өмнөх сарын хүлээгдлээс 21 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн байна.

УГТЭ-т доплерграфийн шинжилгээнд 12, зүрхний эход харуулахаар 5, зүрхний цахилгаан бичлэг 61 үйлчлүүлэгч, хэвлийн ЭХО 59, тархины цахилгаан бичлэг 9 үйлчлүүлэгч тус бүр 1-2 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ. Өдөртөө үйлчлүүлсэн 110 үйлчлүүлэгч байна.


ХСҮТ-д анх удаа үзүүлэхээр дугаар авсан 107 үйлчлүүлэгчээс өдөртөө үйлчлүүлсэн 38, 7 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэлтэй 37, 1-6 хоногийн хүлээгдэлтэй 32 үйлчлүүлэгч байна. Үүнд: бүдүүн шулуун гэдэсний дуран 3, КТГ 35, ходоодны дуран 16, хэвлийн ЭХО 53 үйлчлүүлэгч тус бүр 1-14 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлжээ. Дурангийн 1 кабинет ажиллаж байгаа тул ходоод дурандуулах шаардлагтай тасгийн эмчлүүлэгч, яаралтай тусламжаар ирж буй үйлчлүүлэгчид 7 дээш хоногоор хүлээн үйлчлүүлж байна. Мамаграфийн аппарат эвдэрсэн тул оношлогоо хийгдээгүй байна.

СЭМҮТ-ийн эмгэг сэтгэл судлалын шинжилгээ хийлгэхээр 264 үйлчлүүлэгч бүртгэгдсэний 130 өдөртөө, 35 үйлчлүүлэгч 1 хоног, 25 үйлчлүүлэгч 2 хоног, 5үйлчлүүлэгч 3-6 хоног, 39 үйлчлүүлэгч 7-14 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

УНТЭ, УХТЭ, УГТЭ-ийн оношлогооны кабинетийн 6-р сарын хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:



СЭМҮТ-ийн эмгэг сэтгэл судлалын шинжилгээний
5, 6, 7-р сарын хүлээгдэл /үйлчлүүлэгчийн тоогоор/



Гурав. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн лабораторийн шинжилгээний хүлээгдэл:

2018 оны 7 дугаар сард УНТЭ лабораторийн шинжилгээний хүлээгдэл мэдээлэгдээгүй УХТЭ, УГТЭ-т лабораторийн шинжилгээний хүлээгдлийг бүртгэн мэдээлсэн.

УХТЭ-т лабораторийн нийт хүлээгдэл 798 үйлчлүүлэгч 1-6 хоногийн хүлээгдэлтэй байна. Үүнд:


- Цусны ерөнхий шинжилгээ 73
- Шээсний ерөнхий шинжилгээ 104
- Биохимийн шинжилгээ 780
- Бактериологийн шинжилгээ 43
- Иммунологийн шинжилгээ 90
- Коагулаграммын шинжилгээ 15
- Дох/сериологи 23
- Цитологи 23
- Коагулаграммын шинжилгээ 48 үйлчлүүлэгч 1-2 хоног хүлээж үйлчлүүлсэн байна. Өдөртөө үйлчлүүлсэн 433 үйлчлүүлэгч байна.

УГТЭ-т лабораторийн нийт хүлээгдэл 196 үйлчлүүлэгч 1-2 хоногийн хүлээгдэлтэй байна. Үүнд:

- Цусны ерөнхий шинжилгээ 70
- Биохимийн шинжилгээ 91
- Бактериологи 43
- Коагулаграммын шинжилгээ 43 үйлчлүүлэгч 1-2 хоног хүлээж үйлчлүүлсэн байна.

Иммунолог, серологи, цитологи, шээсний ерөнхий шинжилгээ хүлээгдэлгүй. Өдөртөө үйлчлүүлсэн 250 үйлчлүүлэгч байна.

УХТЭ, УГТЭ-ийн лабораторийн кабинетийн 7-р сарын хүлээгдлийг үйлчлүүлэгчийн тоогоор харьцуулсан нь:



Дөрөв. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:

2018 оны 7 дугаар сард хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдлийг УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, ЭХЭМҮТ, УАУТХ, СЭМҮТ бүртгэн мэдээлсэн.

УНТЭ-т 7-р сард нийт 27 үйлчлүүлэгч 1 хоногоос 14 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна. Үүнд: чих хамар хоолойн тасагт 15, хоол боловсруулах тасагт 5 дотоод шүүрлийн тасагт 6 байна.

УХТЭ-т 7-р сард 109 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр 1-14 хүртэл хоногийн хугацаанд хүлээсэн байна. Үүнд: Зүрх судасны тасаг 36, мэс засал 38, уламжлалт эмчилгээ 24 үйлчлүүлэгч тус бүр 1-14 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн байна.

УГТЭ-т 7-р сард нийт 115 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнээс: уушигний тасагт 6, чих хамар хоолойн тасагт 39, мэдрэлийн мэс засалд 72 мэдрэлийн тасаг 12 үйлчлүүлэгч тус тус 1-30 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүсэн байна.

ЭХЭМҮТ-ийн эрсдэлтэй жирэмсэн судлалын тасагт 4 үйлчлүүлэгч 1-6 хоногийн хугацаанд хүлээж үйлчлүүлсэн.

ХСҮТ-д 7-р сард нийт 66 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэхээр хүлээгдэлд бүртгэгдсэн байна. Үүнд: 1-3 хоногийн хугацаанд 29 үйлчлүүлэгч, 3-6 хоногийн хүлээгдэлтэй 14 үйлчлүүлэгч, 7-14 хоногийн хүлээгдэлтэй 9 үйлчлүүлэгч, 15-30 хоногийн хүлээгдэлтэй 6 үйлчлүүлэгч, 1 сараас дээш хүлээгдэлтэй 8 үйлчлүүлэгч байна.

Ангиографийн тасаг нь өдөрт дунджаар 10 өвчтөнд ажилбар хийдэг ба тус тасгийн дундаж ор хоног 1.6 тул ажилбар хийлгэхээр хүлээж буй өвчтөний тоо их байна.


Химийн тасгаар өвчтөн 14-21 хоногийн давтамжтай “товлолт” эмчилгээнд хамрагддаг тул хүлээгдэлтэй харагдаж байна.

ХСҮТ нь яаралтай тусламжаар өдөрт дунджаар 10 өвчтөн ирдэг, нийт ирж буй үйлчлүүлэгчдийн 98% нь хорт хавдрын хожуу шатандаа орсон өвчтөнүүд байдаг. Хэвтэх яаралтай шаардлагатай өвчтөнүүдийг хөнгөвчлөх болон бусад мэс заслын тасгуудад хэвтүүлдэг учир орны зөрүүтэй байдал үүсдэг.

УАУТХ-д уламжлалт эмчилгээний тасагт хэвтэн эмчлүүлэхээр 1-3 хоногийн хугацаанд хүлээж байгаа 27 үйлчлүүлэгч, 3-6 хоногийн хугацаанд хүлээж байгаа 23 үйлчлүүлэгч, 7-14 хоног 53 үйлчлүүлэгч буюу нийт 103 үйлчлүүлэгч хүлээгдэлд бүртгэгдсэн байна.

СЭМҮТ-ийн стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 1-3 хоногийн хугацаанд хүлээж байгаа 38 үйлчлүүлэгч, 3-6 хоногийн хугацаанд 16 үйлчлүүлэгч, 7-14 хоногийн хугацаанд 21 үйлчлүүлэгч, 15-30 хоногийн хугацаанд 16 үйлчлүүлэгч буюу нийт 91 үйлчлүүлэгч хүлээгдэлд бүртгэгдсэн байна.

1- 7 сарын хугацаанд СЭМҮТ-ийн неврозын тасагт хэвтэн эмчлэхээр бүртгэгдсэн үйлчлүүлэгчийн хүлээгдэл /тоогоор/:



Тав. НЭМГ-ын харьяа эмнэлгүүдийн хэвтүүлэн эмчлэх тасгийн хүлээгдэл:

НЭМГ-ын харьяа 11 эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тасагт хүлээгдэл бүртгэгдсэн байна. Эдгээрээс хамгийн олон хоногийн хүлээгдэл Сонгинохайрхан дүүргийн дотор 130, мэдрэл 40, Чингэлтэй дүүргийн дотор 82, Наркологийн төв 31 үйлчлүүлэгч тус бүр 3-30 хоногийн хүлээгдэлтэй үйлчилсэн байна.

Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын 2018 оны 7-р сарын хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний хүлээгдлийг хүснэгтээр харуулав.

Үзлэгийн кабинетын нэр	Үзүүлэлт	СХД ЭМТ	ХУД ЭМТ	ЧД ЭМТ	НД ЭМТ	БН ЭМТ	БГД ЭМТ	БЗД НЭ	СБД НЭ	ХУД НЭ	СХД НЭ	Наркологийн эмнэлэг
Мэдрэл	Ор хүлээж байгаа өвчтний тоо	40	0	0	0	0	0	0	0	3	0	0

	1-3 хоног	7								3		
	3-6 хоног	5	5			4	7					
	7-14хоног	4	3			5	3					
	15-30 хоног	24				29						
	1 сараас дээш											
Дотор	Ор хүлээж байгаа өвчтний тоо	130	35	82	31	0	25	0	0	8	0	0
	1-3 хоног	18	13	47	10		3			8		
	3-6 хоног	33	10	22	4		14					
	7-14хоног	46	12	13	8		8					
	15-30 хоног	33			9							
	1 сараас дээш											
Ахмадын эмнэлэг	Ор хүлээж байгаа өвчтний тоо	40	0	0	0	0	6	0	0	0	0	0
	1-3 хоног	13					6					
	3-6 хоног	27										
	7-14хоног											
	15-30 хоног											
	1 сараас дээш											
Уламжлалт	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	5	0	0	0	0	0	0	0
	1-3 хоног				2							
	3-6 хоног				3							
	7-14хоног											
	15-30 хоног											
	1 сараас дээш											
Хавдар	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	1-3 хоног											
	3-6 хоног											
	7-14хоног											
	15-30 хоног											
	1 сараас дээш											


Наркологийн тусламж үйлчилгээ	Ор хүлээж байгаа өвчтний тоо	0	0	0	0	0	0	0	0	0	0	31
	1-3 хоног											16
	3-6 хоног											15
	7-14хоног											
	15-30 хоног											
	1 сараас дээш											

Нийслэлийн түргэн тусламжийн төвд 6 дугаар сард 24220 дуудлага бүртгэгдсэний 40.9 %-ийг 0-20 минутад, 32.6 %-ийг 21-40 минутад, 15.8%-ийг 41-60 минутад, 10.8 %-ийг 1 цагаас дээш хугацаанд хүрч үйлчилсэн байна.

Нийслэлийн түргэн тусламжийн төвд 7 сард ирсэн дуудлагын тоо /хүрч үйлчилсэн хугацаагаар/

№	Үзүүлэлт		7 сар	
			Дуудлагын тоо	Хувь
1	Нийт дуудлага		24220	100%
2	Хүлээгдлийн минут	0-20 минут	9897	40.9%
3		21-40 минут	7887	32.6%
4		41-60 минут	3820	15.8%
5		1 цагаас дээш	2616	10.8%

Нийслэлийн түргэн тусламжийн төвийн тусламж үйлчилгээний 2018 оны сүүлийн 4 сарын хүлээгдлийн мэдээг графикаар харуулахад:



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ, ЛИЦЕНЗИЙН АЛБА

